



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 26 өдөр

Дугаар А/493

Мөрөн сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээ
шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 37 дугаар зүйлийн 37.1, 37.2, 38 дугаар зүйлийн 38.1, 38.2, 38.4, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаал, 2023 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн А/133 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газар эзэмших эрхийн гэрчилгээгээ бусдад шилжүүлэх хүсэлт гаргасан 4 иргэний нийт 0.1351га (1351м²) газрыг хавсралтаар тус тус шилжүүлэн эзэмшүүлсүгэй.


2. Уг захирамжаар газар эзэмшиж байгаа иргэдтэй газар эзэмших эрх зүйн баталгаажилт хийж, Улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг), Улсын бүртгэлийн хэлтэс (Б.Мөнгөнзул)-т тус тус зөвшөөрсүгэй.


3. Захиргааны актыг ажлын 5 хоногийн дотор эрх, ашиг сонирхол хөндөгдөж буй этгээдэд мэдэгдэж, баримтжуулсан захиргааны актыг хувийн хэрэгт бүрдүүлэлт хийж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг)-т үүрэг болгосугай.

4. Аймгийн Засаг даргын захирамжийг эс зөвшөөрвөл захирамжийг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор аймгийн Засаг даргад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай. 5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (Ш.Дамдиндорж)-д үүрэг болгосугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ





ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХИЙН ГЭРЧИЛГЭЭГ БУСДАД ШИЛЖҮҮЛСЭН ИРГЭДИЙН ЖАГСАЛТ

№	Эрх шилжүүлж байгаа иргэний овог, нэр, регистр	Эрх шилжүүлэн авч байгаа иргэний овог, нэр, регистр	Нэгж талбарын дугаар	Газрын зориулалт	Газрын байршил, хаяг	Газрын хэмжээ /м2/	Газар эзэмшүүлэх хугацаа	Хүчингүй болгож буй захирамжийн дугаар	Тайлбар
1	Хариад гэрүүд овгийн Шарав Доржжигид (РЕ71041873)	Дайртан овгийн Жигжид Золбоотөгс (РЮ84020404)	6712016053	Гэр, орон сууцны хашааны газар	8-р баг 9-60а тоот	177	11	Аймгийн Засаг даргын 2023.08.02-ны өдрийн А/417 дугаар захирамжийн хавсралтын 6 дахь заалт	Газар эзэмших эрх шилжүүлэх гэрээгээр
2	Шарнууд овгийн Ганбаатар Буянхишиг (РИ89062401)	Боржигон овгийн Дулмаа Сунжээ (РХ96120605)	6712013065	Гэр, орон сууцны хашааны газар	13-р баг 25-6 тоот	446	27	Аймгийн Засаг даргын 2023.05.25-ны өдрийн А/278 дугаар захирамжийн хавсралтын 1 дэх заалт	Газар эзэмших эрх шилжүүлэх гэрээгээр
3	Бээсүд овгийн Ванчигдорж Энхболд (РХ70060914)	Бээсүд овгийн Энхболд Намунтэс (РЭ95081224)	6712014108	Гэр, орон сууцны хашааны газар	14-р баг Баянбуурал-1 143 тоот	700	10	Аймгийн Засаг даргын 2018.09.21-ний өдрийн А/491 дүгээр захирамжийн хавсралтын 1 дэх заалт	Өвлөх эрхийн гэрчилгээгээр
4	Сутай овгийн Дорж Мөнхзаяа (ТА83100571)	Бархас овгийн Хишигмөнх Мөнх-Эрдэнэ (РЭ81112411)	6712016684	Автомашинны гараж	8-р баг 18 дугаар байрны урд талд	28	3	Аймгийн Засаг даргын 2021.06.24-ний өдрийн А/317 дугаар захирамжийн хавсралтын 3 дахь заалт	Газар эзэмших эрх шилжүүлэх гэрээгээр

Нийт газрын хэмжээ: 1351м²

Handwritten signature